

“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

№ 01/2022

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай.

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, СЗХ-ны 2020 оны 28-р тогтоол, “Түмэн шувуут” Хувьцаат компанийн дүрмийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Түмэн шувуут” ХКомпанийн 2021 оны цэвэр ашгийн 30 хувийг Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахыг зөвшөөрсүгэй.

2. Нэгж хувьцаанд 10.4 төгрөгийн ашиг тараахыг гүйцэтгэх захирал /Ж.Болд/ болон ерөнхий нягтлан бодогч Н.Должинсүрэн нарт үүрэг болгосугай.

3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

4. Ногдол ашгийг “ҮЦТХ” ХХК-тай гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдэд 2022 оны 07-р сарын 01-ний өдрийн дотор мөнгөн хэлбэрээр тараасугай.

5. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал /Ж.Болд/-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



И.ЭРХЭМБАЯР